



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр


Дугаар 83

Номгон

Г Эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 а, в, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тендер зарлаж 52,0 сая төгрөгөөр худалдан авсан Баянхонгор аймгийн Ерөнхий шүүгчийн албан тушаалын Дуурсах 3 дугаар багт байрлах 88 дугаар байрны 1 дүгээр орц 01 тоот 53м² талбай бүхий 2 өрөө орон сууцны барилгын эзэмшигчээр аймгийн Засаг даргын Тамгын газрыг тогтоосугай.
2. Эзэмшигч тогтоосон хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



0117223